



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/63

Хажуу шинэ-Ус

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Гал унтраах багаж хэрэгслийг хадгалах байр барих ажлын 71,732,621.00 (Далан нэгэн сая долоон зуун гучин хоёр мянга зургаан зуун хорин нэг) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Бий энд ватст" ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д олгосугай.

2. Гал унтраах багаж хэрэгслийг хадгалах байр барих ажлыг захиалагчийн гаргасан саналд үндэслэн чанар сайтай хийж гүйцэтгэхийг "Бий энд ватст" ХХК-ний гүйцэтгэх захирал (М.Баасанжав)-д даалгасугай.

3. "Бий энд ватст" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Санхүү албаны дарга (Н.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Т.АРИУНАА

